



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА АГЕНТЛАГ,
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ,
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, БОЭТ-ИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024-03 сар

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Нэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2023 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрсэн түвшинг тогтоон, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Үнэлгээг харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс ирүүлсэн тайлан, яамны холбогдох газар, хэлтсүүдээс гаргаж өгсөн мэдээ, мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлт, Хэрэглэгчийн үнэлгээний тайланг үндэслэн гүйцэтгэсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалын дагуу дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

Үнэлгээний нэгдсэн хүснэгт

Үзүүлэлт		Жин	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний жин
№	1	2	3	4
1	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	0.20	80.1	16.0
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	0.15	35.7	5.4
3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	0.30	66.4	19.9
4	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт	0.15	90.0	13.5
5	Хэрэглэгчийн үнэлгээ	0.20	87.0	17.4
Үнэлгээ			72.2	

3.1 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.5 хүснэгтийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайлагнасан байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 онд 80.1%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 16.0 байна.

- ❖ Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тусгаж оруулснаас гадна өөрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, өвөрмөц онцлог зэргийг зайлшгүй тусган төлөвлөх ёстой. Үнэлгээнд хамрагдсан байгууллагууд эдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааг холбогдох чиглэлээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг тайлагнасан байна.
- ❖ Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарт дараах цахим үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна:
 - Эрүүл мэндийн статистик тоон мэдээллийг Tableau програмаар боловсруулалт, анализ хийж Дашбоард мэдээлэл үүсгэн www.1313.mn цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд 28 төрлийн мэдээллийг хүргэн ажиллаж байна. Уг мэдээллийг иргэдэд ойлгомжтой байлгах зорилгоор хүснэгтэн байдлаар, газрын зураг хэлбэрээр, баганан, шугаман, туузан диаграммаар харагддаг болгосон байна.
 - Дээрх цахим хуудсаар дамжуулан эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 2022 оноос эхлэн цахимаар авдаг болсон.
 - Салбарын хэмжээнд бүх төрлийн сургалт, уулзалт, зөвлөгөөнийг танхим болон цахим хэлбэрээр явуулж хэвшсэн байна.
 - Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх хүсэлт, шийдвэрлэлт, олгох, сунгах зэрэг ажлууд бүрэн цахимжсан.
 - Салбарын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн програм хангамжийг нэвтрүүлж, хүсэлт болон холбогдох материалыг 100% цахимаар хүлээн авч шийдвэрлэн ажиллаж эхлээд байна.

3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр нь Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх болон Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах гэсэн 2 үндсэн чиглэлээр хэрэгжсэн байх ёстой. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр:

1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт;
2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт;
3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн зэрэг үйл ажиллагаа тус бүр нь шалгуур үзүүлэлттэй.

Харин Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

1. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх
2. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх
3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх
4. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу ирүүлсэн тайланд үндэслэн үнэлгээг гүйцэтгэлээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд 35.7%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 5.4 байна.

3.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтын “Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт”-ийн дагуу үнэлэхэд хэрэгжилт 66.4%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 19.9 байна.

- ❖ Олон улсын түвшинд орны фонд ашиглалтын хамгийн тохиромжтой хэмжээг 80-85% хувь гэж үздэг ба 85-аас их бол эмнэлгээс шалтгаалсан халдвар гарах эрсдэлийг нэмэгдүүлдэг бол 80-аас бага байх нь эмнэлгийн ор хэт их, эрүүл мэндийн тусамж үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулдаг байна. 2023 онд улсын хэмжээнд эмнэлгийн орны фонд ашиглалт 66.1%, Улаанбаатарт 67.4 %, аймгийн дундаж 64.6% байна.

- ❖ Артерын даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь аймгийн дунджаар 51.2 ба Архангай, Баян-Өлгий, Булган, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Завхан зэрэг аймгууд аймгийн дунджаас доогуур, Говь-Алтай, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий зэрэг аймгууд аймгийн дунджаас дээгүүр байна.
- ❖ Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь аймгийн дунджаар 15.9 ба 21 аймгийн эрүүл мэндийн газрын харьяа анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний хувь хангалттай сайн байгаа нь харагдаж байна.
- ❖ Улсын хэмжээнд дэх товлот дархлаажуулалтын хувь 90 хувиас дээш үзүүлэлттэй 2023 онд хүрэх түвшинд хүрсэн байна.
- ❖ Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь улсын хэмжээнд 90 хувиас дээш байгаа боловч 2023 онд эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдсэнээс 4 нь орон нутагт буюу Говь-Алтай, Дорноговь, Сүхбаатар, Увс аймгуудад тус бүр 1 бүртгэгдсэн байна.
- ❖ 2023 оны жилийн эцсийн байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг аймгуудаар харьцуулбал, Өвөрхангай, Төв аймгуудын хувьд нялхсын эндэгдлийн түвшин өмнөх оны мөн үеэс буурсан хэдий ч улсын дундаж үзүүлэлтээс өндөр; Булган, Баян-Өлгий, Завхан, Сэлэнгэ аймгуудад болон нялхсын эндэгдлийн түвшин өмнөх оноос 1-8 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 2.6-4.5-аар ихэссэн байна.
- ❖ 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Баян-Өлгий, Төв, Булган, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна. Эдгээрээс Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бол Төв, Булган, Архангай, Хөвсгөл аймгуудад өмнөх оноос буурсан хэдий ч аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр байна.
- ❖ 10000 хүн амд ногдох халдварт өвчнийг аймгуудаар авч үзвэл Дорнод, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Сүхбаатар аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна.

3.4 Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагуудын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүд нэмэгдсэн ба уг хуулийн дагуух шалгуур үзүүлэлтээр ил тод байдлыг үнэлсэн болно. Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг:

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод байдал
2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал
3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал
4. Үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдал
5. Бусад мэдээллийн ил тод байдал гэсэн 5 үндсэн чиглэлээр хэрэгжилтийг гарган үнэлсэн.

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын нийтийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт 90.0%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 13.5 байна.

3.5 Хэрэглэгчийн үнэлгээ:

Эрүүл мэндийн сайдын 2022 оныс А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.8 дахь хэсэгт салбарын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцсан зохион байгуулж, 5.8.4 дэхь хэсэгт заасанчлан уг үнэлгээний дүнг эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд шууд ашиглахаар тусгагдсан.

Журам шинэчилэгдэн батлагдсантай холбоотой ЭМХТ нь 2022 оноос хойш 2 дахь удаа салбарын хэмжээнд хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Сүхбаатар аймгийн хэрэглэгчийн үнэлгээ 87.0% ба үнэлгээнд эзлэх хувь 17.4 байна.

Дөрөв. Үнэлгээний нэгдсэн дүгнэлт ба зөвлөмж

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилт 72.2%-ийн гүйцэтгэлтэй “С” буюу “хангалттай” гэж үнэлэгдэв.

Эрүүл мэндийн байгууллагуудад өгөх нэгдсэн зөвлөмж:

- Тайлант жилд тухайн асуудлын хүрээнд гарсан өөрчлөлтийг (ахиц, дэвшил, бууралт) тодорхой гаргахын тулд тоон үзүүлэлттэй, харьцуулалт хийх зарчмаар тайлагнах
- Байгууллага бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг иж бүрэн тайлан, хэрэгжилтийн хамт албан бичгээр Эрүүл мэндийн яаманд ирүүлж хэвших
- Тайланг хэт нуршуу биш, товч бөгөөд тодорхой, Журмын дагуу хоёр мянган тэмдэгтэд багтааж тайлагнаж хэвших
- Төрийн алба хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг тайлагнахдаа журмын дагуу 4 цагаас дээш сургалтыг тайлагнах, сургалтын төлөвлөгөө, үр дүн, ач холбогдлыг тодорхой тайлагнах
- Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж хэвших
- Монгол Улсын 2021 оны “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, ил тод байдалд тавих дотоод хяналтыг сайжруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт буурч байгаад байгууллага бүр дүгнэлт хийж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
- Үндэсний лавлагаа төвүүд нь улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, тоон мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлж ажиллах

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжлэх болон холбогдох баримт материалыг худалдан авагч буюу ЭМДЕГ-т хугацаанд нь хүргүүлэх, нөгөө талаар ЭМДЕГ нь зардлын санхүүжилтийг хугацаанд нь олгох, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааы тасралтгүй байдлыг хангах, өр авлага үүсгэхгүй ажиллах
- Эрүүл мэндийн байгууллагууд хэрэглэгчийн үнэлгээний хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эмнэлгийн удирдлагын зүгээс анхаарч, хэрэглэгч нарыг арга зүйгээр ханган ажиллах

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ ХШҮДАГ